



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

Биеийн тамир, спортын газрын  
ДАРГА Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ ТАНАА

2023.02.13 № 02/28  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Биеийн тамир спортын газар нь урьд жилүүдэд орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан ба тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын багцад Биеийн тамир, спортын улсын хороо гэсэн ерөнхий газартай болж улсын төсвөөс санхүүждэг болсон байна. Ингэснээр спортын төрлөөр тооцсон санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэр зэрэг санхүүжих зарчимд шилжсэн байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд монголын бүх ард түмний 15 дугаар их наадам, өвлийн спортын үндэсний 7 дугаар наадам зохион байгуулагдаж 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 93 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>18,596,600.05</u></b>	<b><u>28,704,428.73</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	578,100.05	4,749,338.73
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	578,100.05	4,749,338.73
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	18,018,500.00	23,955,090.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,172,500.00	6,502,490.00
35110	Тусгай зориулалттай материал	6,172,500.00	6,502,490.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,199,000.00	7,489,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,647,000.00	9,963,600.00
35410	Бичиг хэргийн материал	447,000.00	447,000.00
35420	Аж ахуйн материал	300,000.00	300,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	272,500.00	1,022,500.00
35450	Барилгын засварын материал	7,021,500.00	7,261,500.00
35470	Бусад хангамжийн материал	606,000.00	932,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,880,198,238.60</u></b>	<b><u>3,030,971,553.98</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,880,198,238.60	3,030,971,553.98
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,700,779,238.60	2,851,852,553.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,589,632,943.57	3,962,683,342.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,093,988,648.10)	(1,313,960,642.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,789,584.00	71,789,584.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,125,625.00)	(21,144,583.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	226,037,733.43	264,537,933.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,772,467.57)	(160,193,917.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,126,858.06	56,991,757.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,019,357.57)	(48,066,033.75)
39209	Зам, гүүрийн байгууламж	45,801,530.74	45,801,530.74
39210	Хуримтлагдсан элэгдэл	(14,703,312.96)	(16,586,417.76)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	179,419,000.00	179,119,000.00
39301	Програм хангамж	2,380,000.00	2,380,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(905,000.00)	(1,205,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,944,000.00	177,944,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,898,794,838.65</u></b>	<b><u>3,059,675,982.71</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>33,102,339.72</u></b>	<b><u>22,560.78</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	33,102,339.72	22,560.78
<b>413</b>	<b>Өглөг</b>	33,102,339.72	22,560.78



41310	Ажилчидтай холбогдсон өглөг	328,765.32	22,560.78
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	32,773,574.40	-
41361	Байгууллагад төлөх өглөг	32,773,574.40	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,865,692,498.93</u></b>	<b><u>3,059,653,421.93</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,865,692,498.93	3,059,653,421.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	680,905,756.00	680,905,756.00
51101	Өмч: - төрийн	503,461,756.00	503,461,756.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	177,444,000.00	177,444,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(363,669,371.62)	(169,708,448.62)
51210	Өмнөх үеийн үр дүн	(182,557,493.38)	(363,669,171.62)
51220	Тайлант үеийн үр дүн	(181,111,878.24)	193,960,723.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,548,456,114.55	2,548,456,114.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,898,794,838.65</u></b>	<b><u>3,059,675,982.71</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	578,207,320.82	1,139,445,291.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,270,720.82	372,020,074.66
120	Нийтлэг татварын бус орлого	15,270,720.82	372,020,074.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,270,720.82	372,020,074.66
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,270,720.82	372,020,074.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,936,600.00	767,425,217.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,392,600.00	382,136,872.47
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275,392,600.00	387,965,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(5,828,127.53)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,944,000.00	87,696,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,930,000.00	82,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,474,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,540,000.00	4,350,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	267,600,000.00	297,592,344.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	267,600,000.00	297,841,600.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	(249,255.27)

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	759,319,199.06	945,484,568.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,319,199.06	945,484,568.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,444,592.26	944,819,568.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,099,696.16	221,363,054.47
210101	Үндсэн цалин	171,154,596.16	171,363,947.57
210102	Нэмэгдэл	38,945,100.00	25,857,541.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,709,000.00
210104	Урамшуулал	-	10,432,565.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,555,067.31	27,157,035.71
210201	Тэтгэврийн даатгал	19,199,352.11	18,445,933.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,257,359.98	2,478,506.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,680,797.59	1,759,829.64
210204	Ажилгүйдлийн даатгал	401,596.15	439,757.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,015,961.48	4,033,008.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,633,254.40	249,551,325.40
210301	Гэрэл, цахилгаан	2,869,123.40	4,230,298.80
210302	Түлш, халаалт	234,661,350.00	234,671,725.60
210303	Цэвэр, бохир ус	10,102,781.00	10,649,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,828,877.00	18,606,761.00
210401	Бичиг хэрэг	1,004,250.00	1,567,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,507,247.00	13,825,792.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	597,380.00	1,480,758.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,360,000.00	1,182,410.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,085,600.00	3,366,500.00
210604	Урсгал засвар	1,085,600.00	3,366,500.00
2107	Томиллолт, зочны зардал	952,000.00	3,385,000.00
210702	Дотоод албан томиллолт	952,000.00	3,385,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,631,587.26	4,078,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,631,587.26	803,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	292,775.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	500,000.00
210807	Газрын төлбөр	-	1,478,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,658,510.13	417,311,417.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,118,002.00	194,629,558.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	885,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,540,508.13	221,796,859.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,874,606.80	665,000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,033,400.00	665,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,033,400.00	665,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,841,206.80	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,841,206.80	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(181,111,878.24)	193,960,723.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(181,111,878.24)	193,960,723.00

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>575,816,800.00</b>	<b>767,674,472.47</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>575,816,800.00</b>	<b>767,674,472.47</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	275,392,600.00	382,136,872.47
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275,392,600.00	387,965,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(5,828,127.53)
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,824,200.00	87,696,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,930,000.00	82,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,474,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,420,200.00	4,350,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	267,600,000.00	297,841,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	267,600,000.00	297,841,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>575,816,800.00</b>	<b>767,674,472.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>575,816,800.00</b>	<b>767,674,472.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>566,942,193.20</b>	<b>767,009,472.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	209,855,260.20	225,250,490.47
210101	Үндсэн цалин	178,253,914.15	175,141,220.77
210102	Нэмэгдэл	31,601,346.05	25,967,704.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,709,000.00
210104	Урамшуулал	-	10,432,565.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,069,939.00	27,964,298.00
210201	Тэтгэврийн даатгал	19,505,433.42	19,275,632.50



210202	Тэтгэмжийн даатгал	1,938,738.85	2,157,719.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,550,991.07	1,752,875.74
210204	Ажилгүйдлийн даатгал	370,434.16	434,478.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,704,341.50	4,343,591.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	249,100,000.00	282,356,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,869,123.40	4,262,299.00
210302	Түлш, халаалт	236,128,095.60	267,395,300.00
210303	Цэвэр, бохир ус	10,102,781.00	10,699,301.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,617,094.00	9,307,219.00
210401	Бичиг хэрэг	490,000.00	1,372,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,167,500.00	2,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	597,380.00	1,462,419.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	661,714.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,500.00	3,040,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	204,200.00	2,968,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	
210604	Урсгал засвар	-	2,968,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	952,000.00	3,325,000.00
210702	Дотоод албан томилолт	952,000.00	3,325,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,319,500.00	4,741,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,319,500.00	1,430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	328,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	500,000.00
210807	Газрын төлбөр	-	1,478,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	66,824,200.00	211,096,165.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,824,200.00	209,853,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,242,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,874,606.80</b>	<b>665,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,033,400.00	665,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,033,400.00	665,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,841,206.80	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,841,206.80	
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	680,905,756	2,548,456,114.56	-182,557,493.38	3,046,804,377.17
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	680,905,756	2,548,456,114.56	-363,669,371.62	2,865,692,498.93
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	680,905,756	2,548,456,114.56	-363,669,371.62	2,865,692,498.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	680,905,756	2,548,456,114.56	-363,669,371.62	2,865,692,498.93
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	193,960,723	193,960,723
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	680,905,756	2,548,456,114.55	-169,708,448.62	3,059,653,421.93

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	685,806,600.00	679,729,217.20
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	685,806,600.00	679,729,217.20
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	685,141,600.00	679,064,217.20
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	230,282,000.00	225,250,490.47
210101	Үндсэн цалин	180,350,200.00	175,141,220.77
210102	Нэмэгдэл	27,559,200.00	25,967,704.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,900,000.00	13,709,000.00
210104	Урамшуулал	7,472,600.00	10,432,565.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,740,900.00	27,747,042.93
210201	Тэтгэврийн даатгал	19,573,800.00	19,058,377.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,263,400.00	2,157,719.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,837,400.00	1,752,875.74
210204	Ажилгүйдлийн даатгал	460,700.00	434,478.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,605,600.00	4,343,591.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	272,674,900.00	272,674,899.80
210301	Гэрэл, цахилгаан	4,636,300.00	4,230,298.80
210302	Түлш, халаалт	258,127,300.00	258,095,300.00



210303	Цэвэр, бохир ус	9,911,300.00	10,349,301.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,594,100.00	9,307,219.00
210401	Бичиг хэрэг	1,372,800.00	1,372,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,860,000.00	2,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,462,419.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,325,000.00	3,040,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,000,000.00	2,968,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,968,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,325,000.00	3,325,000.00
210702	Дотоод албан томилолт	3,325,000.00	3,325,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,741,400.00	4,741,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,000.00	1,430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,700.00	328,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	54,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	1,478,700.00	1,478,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	132,783,300.00	133,050,165.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,540,800.00	131,807,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,242,500.00	1,242,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	665,000.00	665,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	665,000.00	665,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	665,000.00	665,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	685,806,600.00	685,806,600.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	685,806,600.00	685,806,600.00
122005	Орон нутгийн төсвөөс	685,806,600.00	685,806,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	10	10
620004	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,824,200.00</b>	<b>87,696,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,824,200.00</b>	<b>87,696,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	32,824,200.00	87,696,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	9,650,000.00
210302	Түлш, халаалт	-	9,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,824,200.00	78,046,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,824,200.00	78,046,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	32824200.00	87696000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32824200.00	87696000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,930,000.00	82,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,474,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,420,200.00	4,350,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир спортын газар нь "Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх биеийн тамирын уралдаан тэмцээний амжилтыг ахиулах санхүүгийн ил тод байдлыг нээлттэй байлгах" гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Байгууллага нь дараах эрх зүйн зохицуулалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

- *Биеийн тамир спортын тухай хууль*
- *Биеийн тамир спортын улсын хорооны тушаал, шийдвэр*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*
- *Төсвийн тухай хууль*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай"*

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир спортын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160.9 сая төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	578,1	4749,3	4171,2
Бараа материал	18,018,5	23,955,0	5936,5
Үндсэн хөрөнгө	2,880,198.4	3,030,971.5	150,773.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,898,795</b>	<b>3,059,675.9</b>	<b>160,880.9</b>
Өр төлбөр	33,102.3	22,5	33,079.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,865,692.7	3,059,653.4	193,960,7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,898,795</b>	<b>3,059,675,9</b>	<b>160,880,9</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага өнгөрсөн оноос 4171.2 мянган төгрөгөөр өссөн нь 3 хүний суутгаагүй урьдчилгаа бөгөөд аудитын тайлангийн зөвлөмжид тусгалаа.
- ✓ Бараа материал 5936.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн аварга шалгаруулах тэмцээний медаль, байгууллагын үйлчилгээний автобусны сэлбэг худалдан авсан.
- ✓ Үндсэн хөрөнгө 150773.1 мянган төгрөгөөр өссөн нь боксын дэвжээ, наадмын талбайн засвар, жудо бөхийн ордныг шинээр орлого авсантай холбоотой байна.



### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны улсын төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 387.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 330.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 387.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 297.8 сая төгрөг нийт 685.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төлөвлөсөн хэмжээнээс 32.3 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн нь төрийн үйлчилгээний ажилтнуудын цалинг орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаад улсын төсвөөс санхүүжсэнтэй холбоотой хорогдуулж өгсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 679.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, уралдаан тэмцээний зардалд зарцуулж, 5.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0.02 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71701/80101-үндсэн ажиллагааны зардал үйл	256,710.2	250,887.8	5,822.4	97
2	71701/80305-бараа үйлчилгээний бусад зардал	88,001.2	87,995.5	5,7	99
3	71701/80802 дээд шатны төсвөөс хуваарилсан	665.0	665.0	0	100
4	71701/82106 нийтийн биеийн тамир	42,588.6	42,588.6	0	100
<b>ДҮН</b>		<b>387,965.0</b>	<b>382,136.9</b>	<b>5,828.1</b>	<b>99</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр улсын аварга, бүсийн аварга, монголын бүх ард түмний спортын наадам, дэлхийн аваргын тэмцээнд оролцсон 1 тамирчны зардал зэрэг спортын холбоонуудад зарцуулсан задал 78046.0 мянган төгрөг, түлш халаалтын он дамжсан ерөнд 9650.0 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаагаа явуулжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Биеийн тамир спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 07-ноос 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 759.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 11 байна.

Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25 гүйлгээ хийгдсэнээс 25 гүйлгээг нэгдсэн цэст мэдээлсэн байна.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар ХАОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсон, ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон зэрэгтэй холбоотой 1.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, орон сууцанд амьдардаг албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон 3.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгджээ.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1200.0	2	1200.0	100
Зөвлөмж	1	3900.0	1	3900.0	100
Нийт дүн	3	5100.0	3	5100.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгой анхаарах асуудал үгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа<sup>1</sup> илэрээгүй.

Харин 38.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 заалт бүхий 3.0 сая төгрөгийн албан шаардлага, 35.1 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулан ажиллах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### 5.1 Албан шаардлага

- ✓ Ахмад спортын мастер, дасгалжуулагч нарын нэрэмжит улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээний зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний "Спортын аварга" арга хэмжээнээс санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамж гарсныг тус газраар дамжуулан санхүүжүүлсэн. Энэ арга хэмжээний Биеийн тамир спортын газарт нийлүүлэгдэх тус бүр 1500.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг ширээний теннис нийлүүлэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно заалтуудыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 5.2.Зөвлөмж

##### 5.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дансанд бүртгэлтэй байгаа 42 нэр төрлийн 30927.0 мянган төгрөгийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн нь Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" хуулийн заалт, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч шийдвэрлэх

#### 5.2.2. Цалин хөлстэй холбоотой

Тайлант жилд ажилтнуудад олгосон урьдчилгааг төсвийн жилд багтаан суутгаж барагдуулаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна." гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж Суутгаагүй урьдчилгаа 4171.2 мянган төгрөгийг нэгдүгээр улиралд багтаан бүрэн суутгаж барагдуулах цаашид он дамжуулсан урьдчилгаа гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээнд ашиглагдах материал авсан эсэх тодорхой бус, анхан шатны баримт дутуу	1	3000.0			1	3000.0	-	-
Элэгдлээрээ өртгөө нөхсөн 42 нэр төрлийн хөрөнгө олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн	1	30927.0					1	30927.0
Суутгаагүй урьдчилгаа	1	4171.2					1	4171.2
Дүн	3	38098.2			1	3000.0	2	35098.2

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: 

Ц.ГАНТУЛГА



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 02/2170427

Ховд

ХОА-2022/40/НА-СТА-ТШЗ  
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ахмад спортын мастер, дасгалжуулагч нарын нэрэмжит улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээний зардлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний "Спортын аварга" арга хэмжээнээс санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамж гарсныг тус газраар дамжуулан санхүүжүүлсэн. Энэ арга хэмжээний хүрээнд Биеийн тамир спортын газарт нийлүүлэгдэх тус бүр 1500.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг ширээний теннис нийлүүлэгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно заалтуудыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх 2 теннисний ширээг "Цаст гурван оргил" холбооноос авч бүртгэлд тусган биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир спортын газрын дарга Ч.Түмэндэмбэрэл, нягтлан бодогч О.Пүрэвсүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР  
АУДИТОР Ц.ГАНТУЛГА

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

021040013

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Биеийн тамир спортын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	ХОА-2022/40/НА-СТА-ТШЗ
-----------------	--	-----------------	------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	02/A/2170427	1.6 Огноо	2023 оны 02 сарын 13	1.7 Мөнгөн дүн / сая төгрөгөөр/	3.0
--	--------------	-----------	----------------------	---------------------------------	-----

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний "Спортын аварга" арга хэмжээнээс санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамж гарсныг тус газраар дамжуулан санхүүжүүлсэн. Энэ арга хэмжээний хүрээнд Биеийн тамир спортын газарт нийлүүлэгдэх тус бүр 1500.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг ширээний теннис нийлүүлэгдээгүй байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Төсвийн зарцуулалттай холбоотой			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.1.Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг		



			хориглоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно заалтуудыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
		Заалт	